



**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл хот үүсч байгуулагдсаны 375 жилийн ойд зориулан байгууллагаа болон биеийн тамир, спортын үйл ажиллагааны сурталчилгааны материалыг хэвлүүлсүгэй.

2. Сурталчилгааны материал хэвлүүлэхэд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Сурталчилгааны материал хэвлүүлэхэд шаардагдах 1.200.000 /нэг сая хоёр зуун мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төвлөрсөн төсвийн сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Сурталчилгааны материалыг өндөр түвшинд хийлгэхийг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500143